



Б.МӨНХБААТАР
ХСИС-ийн Шүүхийн
шийдвэр гүйцэтгэлийн
сургуулийн Нийгмийн
ажлын тэнхимийн
багш, сэтгэл судлалын
магистр, ахлах дэслэгч

ЭМЭГТЭЙ ЯЛ ЭДЛЭГСДИЙН СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ ОНЦЛОГ

\\Гадаад орнуудын жишээ дээр\\

Хураангуй: Эмэгтэй ял эдлэгсдийн дунд сэтгэцийн болон сэтгэл зүйн ямар нэг өөрчлөлт болон бусад төрлийн эрсдлүүд түгээмэл байдаг талаарх олон улсын үзэл хандлагыг харьцуулан судалсан болно.

Түлхүүр үг: Сэтгэцийн эрүүл мэнд, эмэгтэй ялтан, нийгэм хүн ам зүй, сэтгэцийн эмгэгүүд

Хүн төрлөхтний хөгжлийн явцад эмэгтэй ял эдлэгсдийн сэтгэл зүйн онцлогийг эрэгтэйчүүдийнхтэй харьцуулан судалсан байдаг. Дөнгөж өнгөрсөн зуунаас эхлэн хорих ял эдлэгсдийн сэтгэл зүйн онцлог болон сэтгэцийн эрүүл мэндийн талаар яригдаж эхэлсэн түүхтэй. Тэр дундаа эмэгтэй ял эдлэгсдийн сэтгэл зүйн онцлогийн талаар мөн тэдний хорих ял эдлүүлэх газар буюу нийгмээс тусгаарлах хэлбэр нь тэдний сэтгэл зүйд хэрхэн нөлөөлж буй талаар сонирхон судлсан байдаг.

Хүн өөрийн амьдралын туршид олон төрлийн асуудалтай тулгардаг бөгөөд тэр болгонд сайн муу ямар нэг шийдвэр гаргах зайлшгүй шаардлага тулгардаг. Өнгөрсөн зууны 30-аад оноос сэтгэл зүйн үйлчилгээ нь хүнийг өөрчлөхөд тэр дундаа ял эдлэгсдийг өөрчлөх, нийгэмшүүлэхэд илүү үр дүнтэй хэрэгсэл гэсэн үзэл хандлага дэлгэрсэн бөгөөд үүнтэй уялдан олон улсын хэмжээнд энэ чиглэлийн алба хаагчид буюу сэтгэл зүйчидийн орон тоо бий болсон байна¹. 1970-аад оны сүүлээс ял эдлэгсэд дээр туршиж батлагдсан, илүүтэй боловсронгуй болгосон судалгааны хэрэглэгдэхүүнүүд бий болсон бөгөөд 1980-аад онд ял эдлэгсдийн зүгээс эрчимтэй гарч эхэлсэн нийгмийг цочроосон үйлдлүүд буюу хорих ангиас оргох болон гэмт хэргийн гаралт үзүүлэх хариу үйлдлийн талаар илүүтэй анхаарал хандуулан судалж эхэлжээ. Гэсэн хэдий ч 90-ээд оны эхээс эхлэн хувь хүний сэтгэл зүйн онцлог болон тэдгээрт үзүүлэх нөлөөллийн арга хэмжээ эрчимтэйгээр сэргэж эхэлсэн түүхтэй.

Ял эдлэгсдийн онцлогийг судлах сэтгэл зүйн судалгаа шинжилгээний ажлууд гагцхүү зөвхөн эрэгтэй ялтан, хоригдогсод дээр түлхүү тулгуурлаж байсан бөгөөд өнгөрсөн зууны 80-аад он

хүртэл эмэгтэй ял эдлэгсдийн талаарх сэтгэл зүйн асуудлыг “хүндрэлтэй” буюу хэцүү гэсэн тодотгол дунд хамаатуулан охигдуулж байжээ². Энэ талын асуудлыг орхигдуулж байсан шалтгааныг авч үзвэл хорих ангийн алба хаагчдын “эрэгтэй алба хаагч” зүгээс тайлбарлахадаа-илүү асуулт асуудаг, удирдлагад ямар нэгэн асуудлаар илүүтэй ханддаг, гаргасан шийдвэрийг байнга үгүйсгэн өөрсдийн үйлдлээ тайлбарлах гэж оролддог хэмээн тодорхойлж байжээ.³ Гэвч энэхүү “хүндрэлтэй” гэсэн тодотгол нь эмэгтэй ял эдлэгсдийн бие физиологийн онцлог зүй тогтол болон ямарваа нэг хэлбэрийн хүчирхийллээс үүдэлтэй тодорхой сэтгэл зүйн хямрал, гутрал болон төрх үйлийн өөрчлөлттэй холбоотой байжээ.

Олон улсын сэтгэл зүйчдийн хийсэн харьцуулсан судалгаанаас үзэхэд хорих ял эдлэж байгаа эмэгтэйчүүдийн дунд эзлэж буй сэтгэцийн эмгэгийн хувь эрэгтэй ял эдлэгсдийнхээс харьцангуй өндөр

байдаг байна. Их британий судлаачид ял эдэлсэн эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн сэтгэцийн хямралын талаар судлаж үзэхэд⁴:

Илрэл	Эмэгтэй	Эрэгтэй
Тодорхой бус сэтгэцийн хямрал	14%	7%
Невроз	63%	40%
Архины хамаарал	39%	63%
Бие хүний эмгэг	50%	

Хамгийн хачирхалтай нь бие хүний эмгэгтэй эмэгтэйчүүдийн тоо 50% давж байсан нь эрэгтэй ял эдлэгсдийн дунд эзлэх хувиас даруй хэд дахин их байжээ. Эдгээр судалгааны хариу урьд нь Их британий эрүүл мэндийн яамнаас хийгдэж байсан судалгааны үр дүнтэй /эмэгтэй ял эдлэгсдийн дунд шизофрения, невроз, архи болон сэтгэц нөлөөт эм бэлдмэлийн хамаарал зонхилж байна/ нийцэж байсан нь хачирхалтай.

АНУ-ын Хууль зүйн яамны тусгай тайлангаас үзэхэд хүнд хэлбэрийн сэтгэцийн эмгэг буюу шизофрения⁵, сэтгэлийн шалтгаант

¹ Ekstedt J., Griffiths C.T. Corrections in Canada: Policy and Practice Toronto. 1988

² Dallao M. Keeping classification current. Corrections Today. 1997.

Gottfredson D.M., Tonry M. Prediction and Classification // Crime and Justice: A Review of Research. Chicago, 1987. Vol. 9.

³ Van Voorhis P., Presser L. Classification of Women Offenders: A National Assessment of Current Practices. U.S. Department of Justice, National Institute of Corrections, Washington: DC, 2001.

⁴ Singleton N., Meltzer H., Gatward R., Coid J., Deasy D. Psychiatric Morbidity Among Prisoners in England and Wales: the report of a survey carried out in 1997 by Social Survey Division of the Office of National Statistics on Behalf of the Department of Health. London: The Stationery Office, 1998.

⁵ Бямбасүрэн.С., Сэтгэцийн эмгэг судлал., УБ. 2013., 548 тал “Дотоод шалтгаантай,

сэтгэцийн эмгэгүүд, ухаан балартах хам шинж нь ял эдлэж буй эмэгтэй ял эдлэгсдийн 24%, эрэгтэй ял элэгсдийн 16% нь илэрсэн талаар дурьджээ⁶.

Канад улсын хувьд сэтгэцийн эрүүл мэндийн талаарх судалгаанаас үзэхэд хоолны дуршлын эмгэг, шизофрения болон депрессийн илрэл эмэгтэй ял эдлэгсэдэд эрэгтэйчүүдийг бодвол гурав дахин их ажиглагдаж байсан талаар тодорхойлжээ. Мөн эрэгтэй ял эдлэгсэдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн дунд хүнд хэлбэрийн сэтгэц нөлөөт эм бэлдмэл \геройн, кокайн\ -ний хэрэглээ их байдаг⁷. Өөрөөр хэлбэл нийгэм хүн амын эмэгтэйчүүдийн эзлэх хувьтай харьцуулахад ял эдэлж буй эмэгтэйчүүдийн дунд сэтгэл зүйн энэ олон төрлийн цочрол гэмтэлийн эх үүсвэр нь өнгөрсөн амьдралтын туршлага буюу хүнд хэцүү амьдрал, бэлгийн болон бие махбодийн хүчирхийлэлтэй холбогдон илэрч байсан талаар дурьдсан байдаг⁸.

шизофрени тэй удамзүйн холбоотой солиорлын шинжээр илэрдэг бүлэг эмгэгийг шизофрени ба шизофрени төст эмгэгүүд гэж нэрлэдэг. Мөн үүнийг солио гэж нэрлэдэг”

⁶ *Ditton P.M.* Mental Health and Treatment of Inmates and Probationers. Bureau of Justice Statistics Special Report NCJ174463. Washington, DC: US Department of Justice. 1999.

⁷ *Laishes J.* The 2002 Mental Health Strategy for Women Offenders. Ottawa: Correctional Service of Canada, 2002.

⁸ *Jordan B.J., Schlenger W.E., Fairbank J.A., Caddell J.M.* Prevalence of Psychiatric

Канад улс дахь засан хүмүүжүүлэх байгууллагын Burnaby төвд улсын хэмжээнд нийт эмэгтэй ял эдлэгсдийн 19% дээр хийгдсэн судалгааны дүнгээс үзэхэд 49% нь бие хүний эмгэгтэй, 67% нь сэтгэц нөлөөт эм бэлдмэлийн хамааралтай, судалгааны явцад 20% нь депрессийн өндөр илрэл, 24% нь түгшүүрийн тодорхой илрэл ажиглагдсан байна⁹.

Бразиль улсын хэмжээнд нийт эмэгтэй ял эдлэгсдийн 80 орчим хувь нь бүх түвшний депрессийн илрэлтэй хэмээн судлагдсан бөгөөд архинд донтох эмгэг болон бэлгийн хүчирхийллийн харилцан хамааралтай хэмээн тодорхойлжээ. Тэдгээр ял эдлэгсдийн түүхийг судалж үзэхэд бие махбодийн болон амь насанд нь аюул занал учруулж байсан үндсэн шалтгаан нь улсын хэмжээнд түгсэн хар тамхины зохисгүй хэрэглээ хэмээн цохон тэмдэглэсэн байдаг¹⁰.

Тус улсын нийт ял эдлэж буй эмэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг нийгэм хүн амын дунд эзлэх эмэгтэйчүүдийн хувьтай

Disorders Among Incarcerated Women: Convicted Felon Entering Prison // Archives of General Psychiatry. 1996. Vol. 53. № 6.

⁹ *Laishes J.* The 2002 Mental Health Strategy for Women Offenders. Ottawa: Correctional Service of Canada, 2002.

¹⁰ *Reeda E., Rajb A., Falboc G., Caminhac F., Deckerd M.R., Kaliel D.C., Missmere S.A., Molnard B.E., Silvermand J.G.* The prevalence of violence and relation to depression and illicit drug use among incarcerated women in Recife,

харьцуулахад харьцангуй өндөр дүн гарч байжээ.

Илрэл	Ял эдлэгсэд	Иргэд
Шизофрения	7%	1%
Липотемия Эндогенная дипрессия\	33%	8%
Архины хамаарал	36%	4%
Хар тамхины хамаарал	50%	4%
Бие хүний нийгэмд харшлах эмгэг	37%	1%

Мөн энэ төрлийн сэтгэцийн болон сэтгэл зүйн ямар нэг эмгэгтэй эмэгтэйчүүд хорих ял эдлэхээр ирэхдээ эрүүл мэндийн болон сэтгэл санааны байдал нь улам дордож ирдэг бөгөөд эмнэлгийн болон сэтгэл зүйн туслалцаа эрэгтэйчүүдтэй харьцуулахад 2-3 дахин илүү шаардагддаг байна¹¹. Гэвч тодорхой зүй тогтол, шат дараатай судлагдаагүйн улмаас энэ төрлийн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх асуудал орхигддог байна. Магадгүй хорих ангийн төсөвлөгдсөн эмчилгээ үйлчилгээний зардал нь эмэгтэй ял

эдлэгсдийн эмчилгээний зардалд хүрдэггүй нь энэхүү жишиг норм нь эрэгтэйчүүдийн жишгээр тодорхойлогдсон байх ч талтай.

Хорих ял эдлэж буй эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн нийгмээс тусгаарлагдсан, өвөрмөц орчинд үзүүлэх хариу үйлдэл нь харилцан адилгүй байдаг бөгөөд эрэгтэй ял эдлэгсдийн хувьд ямарваа нэг тааламжгүй зүйлдээ шууд хариу үзүүлэх буюу зодоон цохион хийх, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсгэх зэргээр илэрдэг бол харин эмэгтэйчүүдийн хувьд эсэргээрээ гаднаа илрэх хариу үйлдэл нь бага байх хэдий ч ихэнх тохиолдол дотоод зовиол, шаналал зэрэг өөртөө буруу өгч энэ илрэл нь даамжрахдаа амиа хорлолт болон бие эрхтэндээ санаатай гэмтэл учруулах хэлбэрээр илэрдэг байна¹². Эдгээр үйлдлүүд нь сэтгэл зүйн ямарваа нэг дарамт болон бие хүний өөрчлөлт эмгэгтэй холбогддог бөгөөд харин нийтлэг байдлаар хорих байгууллагын алба хаагчдын зүгээс ямарваа нэг зүйлийг өөрт ашигтайгаар эргүүлэх болон бусдын

Brazil // International Journal of Law and Psychiatry. 2009. Vol. 32. Issue 5.

¹¹ Alexander P.C., Luper S.L. Family Characteristics and Longterm Consequences Associated with Sexual Abuse // Archives of Sexual Behavior. 1987. № 16.

Russell D.E.H. The Secret Trauma: Incest in the Lives of Girls and Women. New York, 1986.

¹² Baird V., Bavidge L., Bunday R., Deal A., Dholakia L.N., Dick C.C., Gillan C., Hallett J.H., Malleon K., Monaghan K., Morton F., Prashar U., Siddiqui H., Southall A., Stern V., Stevens R., Watson J. Commission on Women and the Criminal Justice System: Interim Report on Women and Offending. London. 2003.

анхаарлыг татах оролдлого хэмээн хардаг¹³ байна.

N.Singleton et al ¹⁴ Их британий хорих ангиудад ял эдлэж буй ял эдлэгсэд дээр хийсэн судалгааны ажилдаа эмэгтэй ял эдлэгсдийн дунд амиа хорлох оролдлого нь эрэгтэй ял эдлэгсэд болон нийгэм хүх амын эмэгтэйчүүдийн дундах эдгээр оролдлогуудтай харьцуулахад харьцангуй өндөр буюу 10 эмэгтэй ял эдлэгсэд тутмын 4 нь амиа ямар нэг байдлаар хорлох оролдлого хийж байсан талаар тодорхойлсон байдаг. 1978-2003 оны Англи болон Уэльсийн хорих ангиудын мэдээллээс үзэхэд эрэгтэй ял эдлэгсэд дунд 1000 хүн тутмын 1 нь, эмэгтэй эдлэгсэд дунд 1000 хүн тутмын 3 нь амиа хоролсон байжээ¹⁵. Тэдгээр амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хоролсон эмэгтэй ял эдлэгсдийн сэтгэл зүйн цочрол,

гэмтэлийн түвшин нь эрэгтэй амиа хорлогчдын үзүүлэлтээс даруй хэд дахин илүү байсныг тогтоожээ.

Хэдийгээр гэмт хэрэг үйлдсэний улмаас хорих ялаар шийтгэгдэж буй эмэгтэйчүүдийн талаар ярихад гэмт хэргийн зүйлчлэл рецидивийн талаар дурьдах зайлшгүй шаардлагатай ч тэдний хувьд нийгмийн бусад төрлийн асуудлуудыг сөхөхгүйгээр тодорхойлоход хүндрэлтэй байж болох талтай. Гэсэн хэдий ч дээрх туршлагуудаас үзэхэд эмэгтэй ял эдлэгсдийн сэтгэцийн цочрол гэмтлийн зэрэг ийм өндөр байгаа нь тэдэнд тохирох сэтгэл зүйн болон сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах үр дүнтэй төсөл, хөтөлбөр үйл ажиллагаа нь хорих ангийн хэмжээнд нэн шаардлагатай зүйл гэж үзэж болохоор байна.

Иймд энэхүү асуудлуудыг шийдвэрлэхэд олон талын судалгаа тэр дундаа шүүх сэтгэцийн болон сэтгэл зүйн оншилгоо судалгааны хүйсийн онцлогт тохирсон туршигдсан аргачлалуудыг нэвтрүүлэн үр дүнг тооцон судлахаас гадна нөхөн сэргээх сэтгэл зүйн хөтөлбөрүүд \амиа хорлох эрсдэл, түрэмгий зан байдлын эсрэг\ нэвтрүүлэх шаардлагатай хэмээн үзэж байна. Өөрөөр хэлбэл хорих ангид ял эдлэж буй эмэгтэйчүүдийн сэтгэцийн цочрол гэмтэл орох магадлал эрэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр байдаг бөгөөд

¹³ Baird V., Bavidge L., Bunday R., Deal A., Dholakia L.N., Dick C.C., Gillan C., Hallett J.H., Malleson K., Monaghan K., Morton F., Prashar U., Siddiqui H., Southall A., Stern V., Stevens R., Watson J. Commission on Women and the Criminal Justice System: Interim Report on Women and Offending. London. 2003.

¹⁴ Singleton N., Meltzer H., Gatward R., Coid J., Deasy D. Psychiatric Morbidity Among Prisoners in England and Wales: the report of a survey carried out in 1997 by Social Survey Division of the Office of National Statistics on Behalf of the Department of Health. London: The Stationery Office, 1998.

¹⁵ Ministry of Justice UK. Statistical Bulletin Offender management caseload statistics 2006, 2007. № 115. Электронная версия: <http://www.justice.gov.uk/docs/omcs2006.pdf>.

энэ төрлийн төрх үйлийн өөрчлөлтүүд нь өнгөрсөн амьдралын туршлага буюу бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлууд нь гүн хэлбэртэй байдаг тул мэргэшсэн сэтгэл зүйчдийн баг, нөхөн сэргээх үйлчилгээ , төрийн болон төрийн бус нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах ажиллагааг нэмэгдүүлэх нь асуудлыг эерэгээр харах боломж өндөрсөх юм.